

ДОРНОД АЙМАГ
БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/38

Чойбалсан

Алсын зайн оношилгооны үйл
ажиллагааны журам батлах тухай

Монгол улсын Эрүүл мэндийн сайдын 2013 оны А/330, 2019 оны А/385 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Алсын зайн оношилгооны үйл ажиллагааны журмыг нэгдүгээр, зөвлөгөө авах бүтцийн зураглалыг хоёрдугаар, цахим зөвлөгөө авахад хөтлөх маягтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмыг мөрдөж ажиллахыг тасгийн эрхлэгч, нийт эмч нарт, алсын зайн зөвлөгөө авах нөхцлийг бүрдүүлж хамтран ажиллахыг мэдээлэл технологийн инженер /Г.Гантулга/, сургалтын менежер /Н.Эрдэнэтуяа/ нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтийг удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал /Ж.Энхчимэг/-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны дарга /Ч.Гэрлээ/-д даалгасугай.

ЗАХИРАЛ  Д.ДОЛЖИН





Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирлын
2025 оны... дугаар/дүгээр сарын... ны/ний
өдрийн... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Алсын зайн оношилгооны үйл ажиллагааны журам

Нэг. Нийтлэг үндэслэл

Алсын зайн оношилгоогоор дамжуулан лавлагаа шатлалын эрүүл мэндийн төвүүдээс төрөлжсөн мэргэжлийн чиглэлээр эмчилгээ оношилгооны зөвлөгөө авах, хамтран ажиллахаар байгуулсан гэрээний дагуу гадаадын эрүүл мэндийн байгууллагаас эмнэлгээс зөвлөгөө авах, өрх, сумын сумын эрүүл мэндийн төвүүдэд төрөлжсөн мэргэжлийн чиглэлээр эмчилгээ, оношилгооны зөвлөгөө өгөх үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Алсын зайн оношилгооны зорилго

Эрүүл мэндийн тусламжийг зайнаас тэгш хүртээмжтэй хугацаа алдахгүй үзүүлэх

Гурав. Алсын зайн оношилгооны үйл ажиллаганд анхаарах асуудал

3.1 Байгууллагаын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Цахим мэдээллийн нууцын тухай хууль ба холбогдох хууль, журам зааврыг чанд мөрдөж, хувь хүний нууцыг хамгаална.

3.2 Зөвлөгөө авахад үйлчлүүлэгчийн зөвшөөрлийг авсан байна. Хэрэв ухаангүй, өөрөө бие даан шийдвэр гаргах чадваргүй бол түүний эцэг эх, асран хамгаалагчаас зөвшөөрлийг бичгээр авна.

3.3 Цахим зөвлөгөө яаралтай тохиолдол 24 цагийн дотор, төлөвлөгөөт бол 1-3 өдрийн дотор авна. Гадаадын гэрээт байгууллагаас цахим зөвлөгөөг 7-14 хоногийн дотор авна.

3.4 Зөвлөгөөг ажлын цагаар авах бол Эмнэлзүй эрхэлсэн дэд захиралд танилцуулж тухайн байгууллагатай холбогдон үүрэгжүүлсэн эмчээс нь, ажлын бус цагт тухайн жижүүрийн багийн эмчээс нь зөвлөгөө авна.

3.5 Өвчтөний мэдээллийг /шинжилгээ, оношилгооны хариуг/ эмчийн цахим хаягаар явуулна.

3.6 Зөвлөгөө авсан эмч нь зөвлөгөө өгсөн эмчийн зөвлөмжийг өвчний түүхэнд дурьдаж, зөвлөмжийг хувиан авч үйлчлүүлэгчийн өвчний түүхэнд хавсаргана.

3.7 Яаралтай тохиолдолд зөвлөгөөг лавлагаа шатлалын эмнэлгийн эмчээс утсаар авч тухайн өвчний түүхэнд тэмдэглэх, өрх, сумын эрүүл мэндийн төвийн эмч нарт зөвлөгөө өгсөн тохиолдолд бүртгэл хөтөлсөн байна.

Дөрөв. Алсын зайн оношилгооны зөвлөгөө өгөх байгууллагын зохицуулагчийн үүрэг

4.1 Ажлын цагаар зөвлөгөө авахаар оруулсан мэдээллийг хүлээн авч бүртгэн Эмнэлзүй эрхэлсэн дэд захиралд танилцуулан холбогдох эмчээр зөвлөгөө өгүүлнэ.

- 4.2 Зөвлөгөөг шуурхай цаг алдалгүй чанартай үзүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 4.3 Цахим зөвлөгөө өгөх өрөөний тоног төхөөрөмж бүрэн бүтэн байдлыг хариуцан сар, хагас бүтэн жилээр тайланг гаргаж өгнө.
- 4.4 Цахим зөвлөгөө өгсөн, авсан тохиолдолд үйлчилгээний хөлсийг ЭМДҮЗ-ийн тогтоолын дагуу олгоно.
- 4.5 Цахим зөвлөгөөг зохицуулах ажлын дотоодын холболтыг Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал, мэдээлэл технологийн инженер, гадаадын холболтыг сургалтын менежер хариуцна.

Тав. Алсын зайн оношилгоо авах эрүүл мэндийн байгууллагууд, чиглэл

- 5.1 Гадаад улсын гэрээт эмнэлэг
- 5.2 Улсын лавлагаа шатлалын төв эмнэлгүүд (УНТЭ, УХТЭ, УГТЭ, ЭХЭМҮТ, ГССҮТ, ХСҮТ, ХӨСҮТ, АӨСҮТ, ЭСҮТ, ЗӨСҮТ, бусад)
- 5.3 Чиглэл:
- 5.3.1 Тархи, нуруу нугас, цээж, хэвлийн хөндийн гэмтлийн тусламж,
 - 5.3.2 Цээж, хэвлийн хөндийн мэс заслын тусламж,
 - 5.3.3 Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж;
 - 5.3.4 Нярай ба 5 хүртлэх насны хүүхдийн эмнэлгийн тусламж.
 - 5.3.5 Зүрх, судасны эмгэгийн оношилгоо, эмчилгээ
 - 5.3.6 Төрөлхийн гаж хөгжлийн оношилгоо, эмчилгээ
 - 5.3.7 Эмгэг судлалын шинжилгээ
 - 5.3.8 Бусад

Зургаа. БОЭТ-өөс бүсийн аймгийн эмнэлэг, сум өрхийн эрүүл мэндийн төвүүдэд алсын зайн оношилгоо үзүүлэх мэргэжлийн чиглэл

- 6.1 Эх барих, эмэгтэйчүүд
- 6.2 Гэмтэл согог судлал / гэмтэл, гэмтлийн мэс засал/
- 6.3 Дотор /Зүрх судас, ангиогарфи, уушиг, бөөр, хоол боловсруулах, дотоод шүүрэл, яс үе хэрх судлал/
- 6.4 Мэс засал /ерөнхий, хүүхэд, хоол боловсруулах, урологи/
- 6.5 Халдварт өвчин
- 6.6 Хавдар, хими эмчилгээ
- 6.7 Тодорхой сэдвээр сургалт зохион байгуулах

Долоо. Алсын зайн үйлчилгээний үндсэн үйл ажиллагаа

- 7.1 Алсын зайн оношилгоо явуулахад зориулагдсан тоноглогдсон өрөөтэй эсвэл зөөврийн компьютер, интернет, камер, чанга яригч, дуу, дүрс дамжуулах бусад хэрэгслээр бүрэн хангагдсан байна.
- 7.2 Алсын зайн оношилгооны зохицуулагч ажилтан, инженер эсвэл холболт хийх үед ажиллах нэг ажилтныг томилон ажиллаж болно.
- 7.3 Алсын зайн оношилгоогоор зөвлөгөө авах эмнэлэгтэй Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал болон телемедицин зохицуулагч ажилтан, инженер урьдчилан эсвэл нэн яаралтай үед 1 цагийн дотор албан бичиг эсвэл утсаар холбогдон зөвлөгөө авах үйлчлүүлэгчийн мэдээлэл, хийгдсэн оношилгоо шинжилгээний хариу, эмчилгээний талаараа мэдээллийг хүргүүлж холболт хийх бэлтгэл ажлыг хангана

7.4 БОЭТ-өөс алсын зайн зөвлөгөө авах эрүүл мэндийн байгууллага нь урьдчилан албан бичиг болон утсаар мэдэгдэх, нэн яаралтай үед 1 цагийн өмнө Эмнэлзүй эрхэлсэн дэд захиралд зөвлөгөө авах үйлчлүүлэгчийн мэдээлэл, хийгдсэн оношилгоо шинжилгээний хариу, эмчилгээний мэдээллийг ирүүлж, телемедицин зохицуулах ажилтантай холбогдон холболт хийх бэлтгэл ажлыг хангана

7.5 Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал үйлчлүүлэгчийн мэдээллийг хүлээн авч холбогдох мэргэжлийн эмч, эмч нарын багт мэдээлж, зөвлөлдөн холбогдоно.

7.6 Төлөвлөгөөт зөвлөгөөг ажлын өдөр, ажлын цагаар зохион байгуулна. Харин нэн яаралтай тохиолдлыг ажлын цагаар бол холбогдох мэргэжлийн баг, ажлын бус цагаар бол жижүүрийн багийн ахлах жижүүр эмч удирдана. Жижүүрийн бүрэлдэхүүнээс өөр мэргэжлийн эмч шаардлагатай бол дуудаж оролцуулж болно.

7.7 Зөвлөгөө өгч, авч байгаа байгууллага нь зөвлөгөөний явцад суралцагч эмчийг байлцуулж болно.

7.8. Алсын зайн үйлчилгээг ашиглан өвчтөний оношилгоо, эмчилгээний асуудлыг шийдвэрлэх шаардлага гарсан даруйд телемедициний үйлчилгээ үзүүлэгч эмнэлгийн Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал, түүний эзгүйд эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын албаны дарга, менежер холбогдон үйлчилгээг удирдан зохион байгуулна.

7.9 Алсын зайн дамжуулалтын зориулалтын өрөөгүй эрүүл мэндийн байгууллагууд утас, цахим сүлжээ буюу ZOOM, GOOGLE MEET платформуудыг ашиглана.

7.10 Гадаадын гэрээт эмнэлгээс телемедициний үйлчилгээг авах тохиолдолд хамтын ажиллагааны гэрээнд заагдсан дүрмийн дагуу ажиллана.

7.11 Алсын зайн оношилгооны зөвлөгөө өгсөн эмчийн эмчилгээ, оношилгооны талаар өгсөн зөвлөмжийг бичгээр авч өвчний түүхэнд хавсаргана. Баталгаат гарын үсгийн цахим хэлбэрийг ашиглаж болно.

Найм. Алсын зайн оношилгоо үйлчилгээ захиалагч болон зөвлөгч байгууллагуудын хүлээх хариуцлага

8.1. Энэхүү журмыг зөрчсөн эмч, мэргэжилтэнд Эрүүл мэндийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.


8.2. Хувь хүн, өвчтөнтэй холбоотой мэдээллийн нууцыг задруулсан албан тушаалтанд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.



Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирлын
2025 оны 06 дугаар/дүгээр сарын 06 ны/ний
өдрийн 1758 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Зөвлөгөө авах бүтцийн зураглал

Нэн яаралтай тохиолдолд





Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирлын
2025 оны 06 дугаар/дүгээр сарын 06 ны/ний
өдрийн 130 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

Цахим зөвлөлгөө авахад хөтлөх маягт

Он.....сар.....өдөр.....цаг.....минут

Эмнэлгийн нэр.....

Өвчтөний овог, нэр

Үндсэн онош.....

Зөвлөгөө авсан эмч нар.....

Зөвлөгөө өгсөн эмч.....

1.Үйлчлүүлэгчийн мэдээллээс тодруулсан нэмэлт асуумж

2.Үйлчлүүлэгчийн бодит байдалд өгсөн дүгнэлт

3.Шинжилгээний хариунд өгсөн дүгнэлт ба зөвлөсөн нэмэлт шинжилгээ

4.Оношийн талаар өгсөн зөвлөмж

5.Эмчилгээнд өгсөн санал